

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг
Ханбогд сум

Иргэдийн хөгжлийн төв
2016 оны 2-р сарын 25

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ээлжит хурал 2016 оны 2 дугаар сарын 25-ны өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Энэ удаагийн Зөвлөлийн хуралд гурван талын гишүүдээс гадна бусад талуудыг хамруулж, өргөтгөсөн байдлаар хийснээрээ онцлог болсон юм. Хуралд Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын (ЭЗХЗОГ) чиглүүлэгч нараас гадна Олон талт мэргэжлийн шинжээчдийн баг (ОТМШБ), Хөндлөнгийн шинжээчдийн багийн (ХШБ) судлаачид анх удаа оролцсон. ОТМШБ бол Ханбогд сумын малчин өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг хэрэгжүүлэх бөгөөд ЖСЛ Консалтинг, Оксфордын их сургууль болон Шинжлэх ухааны академийн Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн судлаачдаас бүрдэж байна. Ундай голын гольдрол өөрчлөлтийн 2-р шатны судалгааг эхний шатны судалгааг хэрэгжүүлсэн ХШБ гүйцэтгэх юм. Мөн тус хуралд Зөвлөлийн гишүүн Малчдын төлөөллийн зөвлөх Оюу толгойн Хяналт ТББ-ын удирдах ажилтнууд оролцсон болно.

Хурлаар хэлэлцэж тохирсон гол асуудал бол ОТМШБ, ХШБ-ийн судлаачдын хэрэгжүүлэх Ханбогд сумын малчин өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ундай голын гольдрол өөрчлөлтийн 2-р шатны судалгааны ажлын талаар Талууд саналаа нэгтгэлээ. Энэхүү судалгааг 2016 оны 3-8 саруудад хэрэгжүүлэх бөгөөд Ханбогд сумын болон малчдын ахуй амьжиргаа, нийгэм соёлын байдалд гарсан сүүлийн 10 жилийн өөрчлөлтийг бодитойгоор хараат бус байдлаар зураглаж гаргах, Ундай голын цутгалан болох Халив-Дугат голын болон Ундай голын сав газрын хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг дуусгах зорилготой юм.

Мөн Талуудын хүсэлтээр ОУСК-ийн Суурин төлөөлөл Туеэн Д. Нгүеэн хүрэлцэн ирж, Зөвлөлийн хуралд оролцсон бөгөөд, түүнд ХШБ-ын 1-р шатны судалгааны тайланг танилцуулсан болно. ЭЗХЗОГ-ын эвлэрүүлэн зуучлагч Скотт Адамс маргаан шийдвэрлэх аргын тухай болон Ханбогд сумын малчдын гаргасан гомдол шийдвэрлэх явцын өнөөгийн байдал, цаашдын үе шатын талаар мэдээлэл хийлээ.

Хуралд оролцогчид Зөвлөлийн хурлын өмнөх өдрүүдэд буюу 2 дугаар сарын 22-24-ны өдрүүдэд ОТ уурхайн талбайд зочилж, уурхайн үйл ажиллагаатай танилцаж, ЭЗХЗОГ-ийн зүгээс зохион байгуулсан Баримт хамтран олж тогтоох тухай хоёр өдрийн сургалтанд хамрагдлаа. Баримт хамтран олж тогтоох тухай сургалтанд сууснаар Талууд болон судлаачид маргаантай асуудлаа ойлгох, судалгааны аргачлалаа боловсруулах, мэдээ баримт цуглуулан дүн шинжилгээ хийж, шийдлийн хувилбар гаргахад хамтран ажиллах үйл явцын талаар мэдлэг мэдээлэлтэй боллоо. Энэ аргачлалыг ОТМШБ-ийн судалгааны явцад хэрэгжүүлэхээр санал нэгдсэн юм. Талуудын хоорондын итгэлцлийг бэхжүүлэх, тулгарсан асуудлыг хамтран шийдэхэд тустай энэхүү аргачлалыг зааж сургасан багш Ларри Диксон болон ЭЗХЗОГ-ийн багт Зөвлөлийн зүгээс гүн талархал илэрхийллээ.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл

Гурван Талт Зөвлөлийн тухай

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГ бол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.